

ОЮУТНЫ СЭТГЭЦИЙН ҮЙЛ ЯВЦЫН ОНЦЛОГИЙГ СУДАЛСАН ДҮН

Ц.Нина, /ЛТИС/ С.Оюунгэрэл ДШС/

Дээд сургуулийн зорилт, агуулга нь оюутнуудад зөвхөн мэдээллийг дамжуулахад харин оюутнуудын танин мэдэх оюун ухааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, тэдэнд бие дааж мэдлэгийг бүтээлчээр эзэмших мэргэжил боловсролоо байнга ахиулах өмнөө тулгарсан асуудлыг оновчтой шийдвэрлэх арга барил олгоход чиглэгдэх ёстой. Тухайлбал, оюутнуудын танин мэдэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж удирдахын тулд багш сурган хүмүүжүүлэгчдээс тэдний нас болон сэтгэл зүйн хувийн онцлогуудыг харгалзаж сургалтын процессыг явуулсан цагт амжилтад хүрнэ гэдгийг туршлага харуулж байна.

Сүүлийн таван жилд УБДС-ийн сэтгэл судлалын тэнхимээс оюутны сэтгэцийн үйл явцын онцлогийг тухайлбал анхаарлын зарим чанар (тогтворжилт, шилжилт), ой тогтоолтын хэв шинж (харааны, сонорын хөдөлгөөний ой), сэтгэхүйн хэлбэр (дүрслэлт сэтгэхүй, хийсвэр сэтгэхүй)-ийн хөгжлийн онцлогийг сургалтын явцад нь тасралтгүй 4 жил дараалан судлав.

Энэхүү судалгааны ажлаар:

1. Одоогийн дээд сургууль нь оюутныг бага курсээс нь (I) эхлэн дээд сургуулийн, сургалтын үйл явцад дасан зохицох ажил хэрхэн явагдаж байгааг

2. Өнөөгийн дээд сургуулийн сургалтын агуулга, хэлбэр, арга барил нь оюутны оюун ухаан, сэтгэцийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг

3. Сургалтын бүхий л явцад (4 жил) оюутны сэтгэцийн хөгжлийн динамикийг судалж тодорхойлох зорилт тавилаа.

Судалгаанд мэргэжил бүрээс нэг нэг анги авч бүгд 120-150 оюутныг хамарч нэг хүнийг нэг жилд 2-3 удаа судалж судалгааны материалд математик-статистикийн боловсруулалт (дундаж тоон үзүүлэлт, квадрат хазайлт, дундаж алдаа, магадлалыг гаргав) хийж үр дүнг нь анги, сурлага, нас хүйс, нийгмийн гарал, сургуульд хаанаас элссэн (хот, хөдөө) гэсэн 6 үзүүлэлтээр гаргалаа. Түүнчлэн сургалтын үйл явц нь оюутны сэтгэхүйн зарим чанар, хийсвэр сэтгэхүй, ой, анхаарлын зарим чанарт хэрхэн нөлөөлж, яаж хөгжиж байгаад гол анхаарлаа хандуулсны зэрэгцээ ер нь тэдгээр нь оюутны эзэмшиж байгаа мэргэжлийн онцлог,

анги, нас, хүйс, сурлагын төвшинтэй хэрхэн хамааралтайг судалсан юм. Ингээд судалгааны материалыг шинжлэн үзэхэд:

I.Ангиар


-Сэтгэхүйн хурдын /дүрсэлж сэтгэх сэтгэхүй/ ерөнхий төвшин эхний 3 курст хийсвэр сэтгэхүй бүх курст нэлээн сул байна.

а. I-0,41, II-0,49, III-0,59, IV-0.64.

б. II-0,47, III-0,59, IV-0,59.

-Анги ахих тутам нийт оюутны сэтгэхүйн хурд дээшилж байна. Харин хийсвэр сэтгэхүй нийт курсийн хэмжээгээр авч үзэхэд III курст үнэн магадлалтай өсч, IV курст III курсээс өөрчлөгдөөгүй байна.

-I курст монгол хэл, зураг хөдөлмөрийн ангийн оюутнууд сэтгэхүйн хурдаар хамгийн дээгүүр үзүүлэлт байсан боловч II курст үнэн магадлалгүй буурч, физик-математик /Ф.М/, хими-биологийн /ХБ/ ангийн оюутны үзүүлэлт үнэн магадлалтай өссөнөөр хурд (ФМ-0,77, ХБ-0,64) хамгийн дээгүүр үзүүлэлттэй болсон байна. Түүнчлэн хийсвэр сэтгэхүй ФМ, ХБ-ийн ангийн оюутнуудад бүх курст илүү хөгжилтэй байна. Харин биеийн тамирын /БТ/ ангийн оюутнуудынх III, IV курст II курсийнхнээс бараг өөрчлөлт гараагүй ба хамгийн доогуур үзүүлэлттэй гарлаа. (Зураг-1а, 1б)



Эдгээр байдлаас үзэхэд дээд сургуулийн сургалтын явц нь оюутны танин мэдэх үйл явц оюун ухаан үйл ажиллагаанд нөлөөлж байна гэж хэлэх үндэстэй. Гэвч зарим салбарт оюутны

сэтгэхүйн хөгжил нэлээн дээгүүр, зарим нь харьцангуй доогуур үзүүлэлттэй байгаа явдал анхаарал татаж байна. Ийм учраас зарим мэргэжлийн хичээлүүдийн хөгжүүлэх агуулгыг сайжруулах, мэргэжлийн хичээлээр сэтгэхүйг хөгжүүлэх ажлыг хийх шаардлага зүй ёсоор гарч байна гэж үзлээ. Тухайлбал, тус сургуулийн хувьд монгол хэл-уран зохиол, зураг, биеийн тамирын мэргэжлүүдээр сэтгэхүйг хөгжүүлэх оюун ухааныг нэлээн ихээр дайчлах талаас нь сургалтын агуулгыг, төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг өөрчлөн сайжруулах, зарим сурах бичиг, гарын авлагыг өөрчилсөн ч болох байна. Гэхдээ доогуур үзүүлэлттэй гарсан мэргэжлийн ангийн сургалтын зохион байгуулалт буруу муу байна гэсэн үг биш гэдгийг хэлэх байна. Нөгөө талаар дээд сургуулийн сургалтын бүх явцад аль ч хичээлүүдээр сэтгэхүйг хөгжүүлэх үйл ажиллагааг зориуд явуулж байх нь зүйтэй юм шиг санагдлаа.

-Аливаа хичээлээр оюутны онолын сэтгэхүйг хөгжүүлэх ажиллагаа ерөнхийдөө дутмаг байгааг хэлэх нь зүйтэй юм.

II. Сурлагаар

Оюутнуудын сурлагын амжилтыг /3,0-3,5/, /3,6-4,0/,

/4,1-4,5/, /4,6-5,0/ гэсэн хэсэг болгон хувааж үзжээ.

-Сурлагын /3,0-3,5/ амжилттай оюутны сэтгэхүйн хүрд I ба II курст /4,1-4,5/ амжилттай оюутнаас, II курст сурлагын бусад амжилттай оюутнуудынхаас бүгдээс 95 хувийн үнэн магадлалтай доогуур үзүүлэлттэй IV курст бүгдээс нь үнэн магадлалгүй доогуур хөгжилтэй байна. Харин сурлагын бусад амжилттай оюутнуудын хооронд /4,1-4,5/, /4,6-5,0/, /3,0-3,5/ өөрөөр хэлбэл сурлагын 3,6-аас дээш дундаж баллтай оюутнуудын хооронд эрс ялгаа байхгүй боловч II курсээс бусад курст сайнаас дээш /4,0-өөс дээш/ сурлагатай оюутнуудын сэтгэхүйн хурд харьцангуй дээгүүр байна.

-Хийсвэр сэтгэхүйн хөгжлийг сурлагын амжилтаар харьцуулж үзэхэд II курст сурлагын /4,1-4,5/, /4,0-5,0/ амжилттай оюутнуудынхаас хийсвэр сэтгэхүй /3,6-4,0/, /8,0-3,5/ амжилттай оюутнууданхаас үнэн магадлалтай илүү хөгжилтэй байлаа. III курст /4,1-4,5/, /4,6-5,0/ амжилттай оюутнуудынх, IV курст /4,6-5,0/ амжилттай оюутнуудын хийсвэр сэтгэхүйн үзүүлэлт /3,0-3,1/-аас үнэн магадлалтай илүү үзүүлэлттэй үйл ажиллагаа байх ёстой.

Бага курст I ба II/ оюутны сурлагын чанар хэлбэлзэлтэй, тэгсэн мөртлөө сэтгэхүйн хөгжил доогуур байгааг дараах шалтгаанаар тайлбарлаж

болох юм:

Нэгдүгээрт бага курсийн оюутнууд дээд сургуулийн нөхцөлд хараахан дасан зохицож чадахгүй нөгөө талаас багш нар бага курст туслах, дэмжих идэвхтэй ажиллуулах тал дутмаг байгаа болов уу гэж үзэв.

Хоёрдугаарт оюутны бие дааж суралцах арга барил, чадвар бүрэн төлөвшөөгүй үед багш бид оюутныг сул орхиж, анхаарлаасаа гарах тал байдаг. (Дээд сургуульд орчихсон тул биеэ даах чадвартай)


Гуравдугаарт ерөнхий боловсролын сургууль, тусгай мэргэжлийн дунд сургууль, дээд сургуулийн залгамж холбоо сул өмнөх шатны сургуулиудад танин мэдэх үйл ажиллагааг хөгжүүлэхэд бага анхаарч байна.

III. Сэтгэхүйн хөгжлийн онцлогийг насаар нь /18-20/, /21-25/, /26-30/, /30-дээш/ дараах бүлэгт хувааж харьцуулан үзэхэд:

-Бүх курст 21-25 настай оюутны сэтгэхүйн хурд ба хийсвэр сэтгэхүй нь насны бусад бүлгээс дээгүүр үзүүлэлттэй байна. Харин 30-аас дээш настай оюутнуудынх хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

-18-20 настай оюутнуудын хийсвэр сэтгэхүй III курстээ 21-25 настай оюутнуудынхтай ойролцоо хөгжилтэй болж ирсэн байна. Өөрөөр хэлбэл 18-20 насанд сэтгэхүй нэлээд түргэн хөгжиж байна. Гэтэл 26-аас дээш настай оюутны хийсвэр сэтгэхүйн үзүүлэлт II курст буурчээ.

- Бүх курст 21-25 настай оюутны сэтгэхүйн хурд 26-гаас дээш настай оюутныхаас үнэн магадлалтай илүү хөгжилтэй байна. /Зураг.3-а, 3-б/



Энэ бүхнээс сэтгэхүйн хөгжил наснаас хамаардаг нь харагдаж байна. Энэ байдлыг үндэслэж дээд сургуулийн анги бүлгийг зохион байгуулах, түүнчлэн сургалтын төлөвлөгөө хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, оюутантай ажиллахдаа насны онцлогийг харгалзах нь зүйтэй

юм. Энэ нь нэг талаас оюутантай тулж ажиллах боломжийг өгч, нөгөө талаас насны онцлогийг харгалзах ганцаарчилсан төрөлжүүлсэн зэрэг хэлбэрээр сургалтыг зохион явуулах, гүнзгийрүүлэн сургах ажлыг хийх боломжтой. Одоогийн байдлаар дээд сургуулийн нэг ангид янз бүрийн насны хүмүүс ижил хөтөлбөр, нэг хэв загвар, аргаар суралцаж байгааг харж үзүүштэй байна.

IV. Хүйсээр

- Сэтгэхүйн хурдыг хүйсээр харьцуулж үзэхэд I курст эмэгтэй оюутны сэтгэхүйн хурд эрэгтэй оюутныхаас 95%-ийн магадлалтай илүү хөгжилтэй байснаа цаашид эмэгтэй, эрэгтэй оюутнуудын хооронд үнэн магадлалтай ялгаа байхгүй бараг ижил төвшинд байна.

-Харин эмэгтэй ба эрэгтэй оюутнуудын хийсвэр сэтгэхүйн хөгжилд II курс үнэн магадлалтай ялгаа байхгүй байснаа III ба IV курст эмэгтэй оюутнуудын хийсвэр сэтгэхүй эрэгтэй оюутныхаас үнэн магадлалтай илүү хөгжилтэй болсон байна.

Эдгээрээс үзэхэд сэтгэхүйн хөгжилд хүйсийн ялгаа бараг нөлөөлөхгүй байна. Харин хийсвэр сэтгэхүй эмэгтэй оюутнуудад илүү хөгжиж байгааг биологийн зүй тогтлоор тайлбарлаж болох юм. Түүнчлэн эмэгтэй оюутнууд сургалтын явцад арай илүү захирагддаг, уян хатан байдагтай ч холбоотой болов уу гэж үзэв. Сэтгэхүйн хөгжлийг нийгмийн гарал, хаанаас элссэн гэсэн үзүүлэлтээр харьцуулахад гоц, ялгаа ажиглагдсангүй. Иймд нийгмийн гарал оюутны танин мэдэх үйл явцад ялгагдах нөлөө үзүүлдэггүй юм байна гэж хэлэх бүрэн үндэслэлтэй.

ДҮГНЭЛТ

Дээд сургуулийн сургалтын агуулга, хэлбэр, арга барил оюутны оюун ухааныг хөгжүүлэх өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна. Оюутны мэдлэгийн цар хүрээ нимгэн онолын мэдлэг хангалтгүй, мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж чаддаггүй, сурлагын чанар харьцангуй муу гэх зэргээр их ярьдаг боловч чухамхүү түүнийг сайжруулах арга замыг судалж бүрэн боловсруулж хараахан мөрдөж чадахгүй байна. Эдгээр асуудлыг цулгүй ярианаас биш харин судалгаа шинжилгээний тодорхой баримт материалд тулгуурлаж, тэдгээр онцлогийг харгалзан сайжруулах арга замаа боловсруулахаас л эхлэх ёстой. Энэ нь сургалтын асуудлыг олон талаас авч үзэх, тэр бүхнийг маш нарийн уялдуулан зохицуулан ажиллахыг шаардсан ажил юм.

Гэтэл манай дээд сургуулиудад аль ч шатны

сургалтыг ихэвчлэн ерөнхий нэг загвараар зөвхөн нэг талаас авч үзсэнээс сургалтын чанарт гологдол гарч байна гэж үзлээ.

Бидний судалгаанаас үзэхэд оюутны танин мэдэх сэтгэхүй, ой, анхаарал гэх мэт үйл явцын хөгжилт нэлээд олон үзүүлэлтээр доогуур төвшинд байгаа нь харагдлаа. Жишээ нь, анхаарлын чадварууд, ялангуяа анхаарлын тогтворжилт, анхаарлын шилжилт аль ч курсэд доогуур үзүүлэлттэй, тэр ч байтугай зарим курсэд буурсан тал ч байсан. Ой тогтоолтыг судалж үзэхэд оюутны харааны ой үзүүлэлт дээгүүр байхад сонорын ой маш доогуур сонор хөдөлгөөний ой дунд зэрэг үзүүлэлттэй. Сэтгэхүйн хувьд судалгаанд орсон оюутны ихэнх нь доод ба дунд төвшинд хамаарагдаж байсан гадна хийсвэр сэтгэхүйн хөгжил аль ч курсэд хамгийн доогуур үзүүлэлттэй байв.

Ийм учраас аливаа мэргэжлийн хичээлийн шинжлэх ухааны үндсийг гүнзгийрүүлэх онолын мэдлэгийн төвшинг өндөржүүлэхийн зэрэгцээ ялангуяа биеийн тамир, зураг хөдөлмөр, монгол хэлний мэргэжлийн хичээлүүдийн онолын агуулгыг өргөжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Одоогийн байдлаас үзэхэд дээрх мэргэжлийн хичээлүүдийн практик тал нь илүү байгаа юм шиг харагдаж байна.

Орчин үеийн нийгмийн хөгжил хийсвэр ба онолын сэтгэхүйн хөгжлийг зүй ёсоор шаардах боллоо. Энэ ажлыг бүх шатны сургуулиудад үе шаттай дэс дараатай хайх ёстой.

Дээд сургуулийн сургалтын явцад оюутны танин мэдэх үйл явцыг хөгжүүлэх нэг арга зам нь мэргэжлийн хичээлийн онол, шинжлэх ухааны үндсийг зөв таньж өгөх анги курсүүдэд орох хичээлийг зөв хуваарилах, түүний уялдаа холбоог сайжруулах асуудал байх ёстой гэдэг нь нотлогдож байна.

Нөгөө талаас дээд сургуулийн багш нарын сурган хүмүүжүүлэх ур чадвар, эв дүй авьяас билэг, гэдэг боловсрол мэргэжлийн төвшин, сурган хүмүүжүүлэх арга барилаас оюутны оюун ухааныг хөгжүүлэх асуудал хамаарах нь зайлшгүй гэдэг нь батлагдаж байна. Иймээс багш нарыг бэлтгэх давтан сургах мэргэжил мэдлэгийг нь ахиулах, ялангуяа ардын сурган хүмүүжүүлэх арга барилд сургах асуудал нэн шаардлагатай байна.

Сургалтын явцад оюутнууд анги ахих тутам сурах үйл явцад дасан зохицож сурлагын чанар нь дээшилж оюун ухаан, сэтгэхүйн хөгжилд шинэ шинэ өөрчлөлт гарч байх зүй тогтолтой юм. Гэтэл судалгааны дүнгээс үзэхэд хими биологи, физик математикийн ангийн оюутныхаас бусад II курсийн оюутны сэтгэлгэхүй, ялангуяа хийсвэр

сэтгэхүйн хөгжилт ихээхэн доогуур үзүүлэлттэй байгаа нь оюутныг бага курсэд /I ба II курсэд/ суралцаж байхад дээд сургуулийн сурах үйл явцад дасган хэвшүүлэх үйл ажиллагаа тун хангалтгүй зохиож байгаагаар тайлбарлаж болох байна. Тэд зөвхөн III курсээс эхлэн дээд сургуулийн сурах үйл ажиллагаанд дасан хэвшиж, бие дааж ажиллах чадвар дээшилж, сэтгэхүй, ой зэрэг сэтгэцийн үйл явц хөгжилд өөрчлөлт гарч суралцах дадал чадвартай болж байна. Гэтэл дээрх үзүүлэлт II курсэд ахисан байдал бараг харагдахгүй байна.

Дасан зохицох ажлыг юуны өмнө мэдээллийг хүлээн авах чадвар, түүнийг боловсруулах арга барилд сургах хамгийн энгийн үйл ажиллагаанаас эхэлж, мэдлэгийг бие дааж бүтээлчээр эзэмших дадал чадвар төлөвшүүлэх замаар гүйцэтгэх ёстой. Тухайлбал, материалын гол санаа, ерөнхий ба түгээмэл шинжийг сэтгэхүйн үйлдэл хийж олох, дасгалыг олон хувилбараар ажиллах, тухайн зүйлд товч бичиглэл, зураглал, тэмдэглэлийг бие дааж хийх гэх зэрэг үйл хөдөлгөөн бага, дутуу хагас хийснээс мэдлэгийг дутуу, дулимаг эзэмших, түүнийгээ амьдралд хэрэглэж чадахгүй, цаашид суралцахад бэрхшээл учрах ч тал байна.

Сэтгэхүйн хөгжлийн талаас авч үзэхэд оюутнаар асуудал шийдвэрлүүлэх, асуудлыг олон талаас нь нягтлан үзэж өөрийн үзэл санаагаар баяжуулах, зарим дүрэм, тодорхойлолт, зүй тогтлыг өөрсдөөр нь гаргуулах ажиллагаа дээд сургуулийн сургалтад харьцангуй бага байгаагаас оюутан зөвхөн сонсогч болон суух явдал газар авчээ. Ийм учраас лекцийн хичээлийн явцад оюутныг өөрийг нь чөлөөтэй, бие дааж ажиллуулах тийм нөхцөл боломжийг бүрдүүлж буй болгох нь зүйтэй гэж үзэв. Оюутны чөлөөтэй бэлтгэх, бие дааж оюун ухааны үйл хийх ажиллагаа “хангалтгүй байгаа нь сэтгэхүйн хөгжлийн үзүүлэлт доогуур байгаагийн шалтгаан гэж үзэж байна.

Дээд сургуулийн сурах үйл ажиллагаанд дасан зохицох үйл удаан байгаа явдал нэг талаар ЕБДС болон дээд сургуулийн залгамж холбоо муугаас ч болж байна.

3. Оюутны сэтгэн бодох үйлийн хурд, ой тогтоолт анхаарлын үзүүлэлтийг насны үе шатаар судалж үзэхэд хөгжилт нь тэдний насны онцлогтой нарийн уялдаатай хөгждөг зүй тогтол ажиглагдаж байгаагийн зэрэгцээ 21-25 нас бол сэтгэхүйн хөгжлийн эрчимтэй үе байдгийг давхар нотолж байна. Нөгөө талаар хийсвэр сэтгэхүйн хөгжилт 26 наснаас бүх курст буурч байгаа хандлага харагдлаа. Энэ нь хүний хөгжилт нь насны үе шаттай холбоотой явагдах ерөнхий зүй тогтолтой боловч сургах үйл явцын чанар

үр дүн өндөр байвал заавал хөгжилт буурах нь зайлшгүй биш гэдгийг бид анхаарч ажиллах шаардлагатай байгаа юм. Судалгаанаас 18-19 насанд, 30-аас дээш насанд үзүүлэлт доогуур байлаа. Энэ бүхэн насны онцлогийг харгалзаж дээд сургуулийн сургалтад ялгавартай хандах, сургалтыг ганцаарчилсан, төрөлжүүлсэн болон бусад олон хэлбэрээр явуулах, хөтөлбөр төлөвлөгөөг олон хувилбараар зохиох, оюутны ачааллыг насны онцлогтой холбон үзэх сургалтын арга барилыг янз бүрээр сонгон авах боломж, нөхцөлийг буй болгож болох байна. Түүнчлэн дээд сургуульд элсүүлэх нас, суралцах хугацаа, үзэх хичээлийн нэр төрөл, агуулга, улмаар аль курсэд ямар ямар хичээлийг хэдэн цагаар оруулах зэрэг олон асуудлыг нас зүйн онцлогтой холбон нарийвчлан үзэх нь зүйтэй юм.

Эцэст хэлэхэд оюутны оюун ухаан танин мэдэх үйл ажиллагааг хөгжүүлэх арга замыг боловсронгуй болгох зорилгоор дээд сургуулийн багш нарын сэтгэл судлалын ухаан онол-практикийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг дэс дараатай зохион байгуулалттай явуулж тэднийг гарын авлага, удирдамж зөвлөлгөөгөөр хангах, тэдэнд туслах төв байх нь зүйтэй гэж үзэв.

Мэргэжлийн боловсрол. 1990. №2